

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 32 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 32.7 дахь хэсэг нэмсүгэй:

“32.7. Ашигт малтмал, газрын тосны салбараас бусад салбарт ажиллах гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг эдийн засгийн өсөлт, үндэсний бүтээн байгуулалт, салбарын бодлого, дотоодын ажиллах хүчний хомсдол зэргийг харгалзан Засгийн газар хөнгөлж, чөлөөлж болно.”

2 дугаар зүйл. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.8 дахь хэсгийн “ажлын байрны” гэсний дараа “төлбөрийн хэмжээг тогтоох,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“32.1. Хуульд өөрөөр заагаагүй бол гадаад ажилтны ажлын байрны төлбөрийн нэг сарын хэмжээг Засгийн газар тогтооно.”

4 дүгээр зүйл. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “10 дугаар” гэснийг “12 дугаар” гэж, 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсгийн дугаарыг “32.8” гэж, 32.8 дахь хэсгийн дугаарыг “32.9” гэж, 32.9 дэх хэсгийн дугаарыг “32.10” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсэг, 23 дугаар зүйлийн 23.10 дахь хэсгийн “Цахим системээр зөвшөөрлийн үйлчилгээ үзүүлэх, цахим системийг ашиглах журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэснийг тус тус хассугай.